



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Г Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны “Зөвшөөрөл олгох тухай” 323 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/1059 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлөөс хянаж зөвшөөрөл олгосон тус газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хяналт үнэлгээ, статистик судалгаа, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Жуулчны аюулгүй байдал, үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Эвент хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Тус газрын төрийн үйлчилгээний албан тушаал Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежерын албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтны албан тушаалын

1159590700

тодорхойлолтыг 16 дугаар, Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

4. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т даалгасугай.

